



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/154

Номгон

“Оюутан-цэрэг” сургалтыг зохион
байгуулж явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.28 Цэргийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7, Засгийн газрын “Журам батлах тухай” 2017 оны 32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Оюутан-цэрэг” сургалтыг 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж явуулсугай.

2.Сургалтыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. “Оюутан-цэрэг” сургалтад хамрагдах их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцаж байгаа бие бялдар, эрүүл мэндийн шалгуур үзүүлэлт хангасан оюутан, суралцагчидтай сургалтыг зохион байгуулан явуулж дүнг 2021 оны 03 дугаар улиралд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб /хурандаа Г.Нэмэхбаяр/-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Б.Батсуурь/-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын
02-ны өдрийн А/154 дүгээр захирамжийн
хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: М.Өнөржаргал -Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Г.Нэмэхбаяр- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн
штабын дарга, хурандаа

Т.Мөнхбат-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын тоо
бүртгэлийн офицер, хошууч

Г.Болдбаатар - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын
дайчилгааны офицер, ахмад

Д.Энхжаргал - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга

Ц.Энхтөр-Боловсрол, соёл урлагийн газрын дарга

М.Мэнджаргал-Биеийн тамир, спортын газрын дарга

Ч.Жавзан - Нэгдсэн эмнэлгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
/ерөнхий эмч/

Г.Батмөнх-Худалдаа Үйлдвэрлэлийн их сургуулийн захирал

Д.Бат-Орших-Политехникийн коллежийн захирал

С.Бямбадорж-Өлзийт мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал

Нарийн бичгийн дарга: Г.Бат-Өлзий- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер, ахмад

_____оОо_____